



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/167

Мөрөн сум

Төсөв зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ний А/682 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон сумдын санхүүгийн албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтнүүдийг шинэ мэдээ мэдээллээр хангах, чадавхжуулах, туршлага судлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулахад 10,000,000 (Арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын санхүүжилт 10,000,000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын "Эрх зүй, нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах зардал"-с гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

